



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/646

Улаанбаатар хот

МУИС-д суралцагч шилжүүлэн
суралцуулах журмыг шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.9 дэх заалт, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг 2024-2025 оны хичээлийн жилийн хаврын улирлын шилжилтээс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирал (ректор)-ын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/367 дугаар тушаалаар батлагдсан “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүрэлдэхүүн/салбар сургууль, нэгжийн удирдлага, Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар) нарт үүрэг болгосугай.


РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1421064879

Ректорын 2024 оны . . . 12 дугаар сарын . . . 17 -ны
өдрийн А/016 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ
ШИЛЖҮҮЛЭН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Гадаад, дотоодын их, дээд сургуулиас Монгол Улсын Их Сургуульд (цаашид "МУИС" гэнэ), мөн МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль, хөтөлбөр хооронд бүх түвшний суралцагч (цаашид "бүртгүүлэгч" гэнэ) шилжин суралцах асуудлыг зохицуулахад энэхүү журмыг (цаашид "журам" гэнэ) мөрдөнө.
- 1.2. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуульд шилжин суралцах хүсэлт гаргасан суралцагчийг "бүртгүүлэгч", шилжилтийн цахим бүртгэлийн системийг "бүртгэлийн нэгдсэн систем" (<https://burtgel.num.edu.mn>), шилжилтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "шилжилтийн комисс", шилжилтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох багш, ажилтныг "шилжилтийн шалгалтын комиссын гишүүн" гэнэ.
- 1.3. Шилжилт авах хөтөлбөр, хяналтын тоог бүрэлдэхүүн/салбар сургуулийн элсэлт, хөтөлбөр сонголт, идэвхтэй суралцагчийн тоо, багшийн ачааллыг харгалзан, бүрэлдэхүүн/салбар сургуулийн саналыг үндэслэн, Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж гаргаж, МУИС-ийн ректорын тушаалаар батална.
- 1.4. Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг шилжилтийн комиссын хурлаар хэлэлцэж, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

ХОЁР. ШИЛЖИЛТИЙН КОМИСС

- 2.1. Шилжилтийн үйл ажиллагааг шилжилтийн комисс хариуцан зохион байгуулна. МУИС-ийн шилжилтийн комисс, шилжилтийн шалгалтын комиссыг ректорын тушаалаар томилно.
- 2.2. Шилжилтийн комиссын дарга удирдлагаар хангаж, комиссын гишүүд зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэн, хяналт тавьж оролцоно.
- 2.3. Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь шалгалт зохион байгуулах, хуваарь гаргах, шалгалтын дүнг системд оруулах, бүртгүүлэгчийн материалыг шалгах, багц цагийн дүйцүүлэлт хийх ажлыг хариуцна.

ГУРАВ. БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ГАДААДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИАС
ШИЛЖИН СУРАЛЦАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 3.1. Гадаадын их, дээд сургуулиас шилжин суралцах хүсэлт гаргасан бакалаврын түвшний бүртгүүлэгч нь сүүлийн 2 жилийн хугацаанд аль нэг улиралд 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. МУИС-тай ижил болон дээгүүр эрэмбэтэй их, дээд сургуулиас

- МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгчийн хувьд нийт суралцсан хугацааны голч дүн 2.5-аас дээш байх;
- 3.1.2. МУИС-иас доогуур эрэмбэтэй¹ их, дээд сургуулиас МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгчийн хувьд нийт суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх;
- 3.2. Гадаад улсын аль нэг дээд боловсролын сургалтын байгууллагаас МУИС-д ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах тохиолдолд элсэлтийн шалгалт (ЭШ)-ын оноо шаардахгүй.

ДӨРӨВ. БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ДОТООДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИАС ШИЛЖИН СУРАЛЦАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргасан бүртгүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 4.1.1. Бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгчийн хувьд хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх, салбар сургуулийн хувьд аль нэг улиралд 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх;
- 4.1.2. Бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгчийн нийт суралцсан хугацааны голч дүн төрийн өмчийн их, дээд сургууль бол 3.0 ба түүнээс дээш, төрийн бус өмчийн их, дээд сургууль бол 3.5 ба түүнээс дээш байх;
- 4.1.3. Шилжин суралцах хөтөлбөрийн ЭШ-ын зөрүүгүй, тухайн элссэн жилийн МУИС-ийн тооцоолсон босго оноог давсан байх.
- 4.2. Хоёрдогч бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгч нь шилжин суралцах хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд аль нэг улиралд 12-оос багагүй багц цаг цуглуулж, нийт суралцсан хугацааны голч дүн 3.0 ба түүнээс дээш байна.

ТАВ. МУИС-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР ХООРОНД ШИЛЖИН СУРАЛЦАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн суралцагч нь өөр хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 5.1.1. Бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгч нь хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд хоёр улирал дараалан тус бүр 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх, салбар сургуулийн хувьд 2 жилийн хугацаанд аль нэг улиралд 12-оос багагүй багц цагийн хичээл амжилттай судалсан байх;
- 5.1.2. Бүрэлдэхүүн сургуульд бүртгүүлэгчийн нийт суралцсан хугацааны голч дүн 2.8 ба түүнээс дээш байх;
- 5.1.3. Суралцаж буй бүрэлдэхүүн/салбар сургуулийн мэргэжлийн хөтөлбөрөөс сонгосон байх;
- 5.1.4. Шилжин суралцах хөтөлбөрийн ЭШ-ын зөрүүгүй, тухайн элссэн жилийн МУИС-ийн тооцоолсон босго оноог давсан байх.

- 5.2. Хоёрдогч бакалаврын хөтөлбөрийн суралцагч хөтөлбөр хооронд шилжих болон сургалтын хэлбэрээ өөрчлөх бол хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд аль нэг улиралд 12-оос багагүй багц цаг цуглуулж, нийт суралцсан хугацааны голч дүн 2.8 ба түүнээс дээш байна.
- 5.3. Хоёрдогч бакалаврын хөтөлбөрийн суралцагч сургалтын хэлбэрээ өөрчлөх тохиолдолд энэхүү журмаар зохицуулагдахгүй бөгөөд холбогдох тэнхим болон сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын асуудал хариуцсан нэгжид хандана.
- 5.4. Бүртгүүлэгч бүрэн дүгнэгдээгүй "I", "E", "N/A" гэсэн үсгэн тэмдэглэгээгүй байна.
- 5.5. Бүртгүүлэгч нь сургалтын төлбөрийн өргүй байна.

ЗУРГАА. МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ ШИЛЖИН СУРАЛЦАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 6.1. Магистр, докторын түвшний бүртгүүлэгч нь хүсэлт гаргах улирлын өмнөх 2 жилийн хугацаанд аль нэг улиралд 6-аас багагүй багц цагийн хичээлийг амжилттай судалсан байна.
- 6.2. Бүрэлдэхүүн сургуульд шилжих бол нийт суралцсан хугацааны голч дүн 2.8-аас дээш байх, салбар сургуульд шилжих бол нийт суралцсан хугацааны голч дүн 2.5 ба түүнээс дээш байна.
- 6.3. Бүртгүүлэгч бүрэн дүгнэгдээгүй "I", "E", "N/A" гэсэн үсгэн тэмдэглэгээгүй байна.
- 6.4. Бүртгүүлэгч нь сургалтын төлбөрийн өргүй байна.
- 6.5. Магистр (мэргэжлийн, судалгааны)-ын хөтөлбөрийн сургалтын хэлбэрээ өөрчлөх тохиолдолд энэхүү журмаар зохицуулагдахгүй бөгөөд холбогдох тэнхим болон Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын асуудал хариуцсан нэгжид хандана.

ДОЛОО. ШИЛЖИЛТИЙН БҮРТГЭЛ

- 7.1. Шилжилтийн бүртгэлийг хичээлийн жилд хоёр удаа буюу намрын улиралд 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал, хаврын улиралд 12 дугаар сарын 10-ны өдрөөс 01 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системээр зохион байгуулна.
- 7.2. Бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн системд и-мэйл хаяг, нууц үг оруулан нэвтэрч зааврын дагуу хүсэлтээ гаргана.
- 7.3. Бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудыг оруулна (МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих хүсэлт гаргах бүртгүүлэгчдэд доорх бичиг баримтыг системд оруулах шаардлагагүй). Үүнд:
 - 7.3.1. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг;
 - 7.3.2. Суралцаж байгаа сургуулийн суралцагч мөн болохыг баталсан тодорхойлолт;
 - 7.3.3. Дүнгийн тодорхойлолт (тухайн сургуулийн сургалтын албаны тэмдэг, албан тушаалтны гарын үсэг, голч дүн, багц цаг бүхий албан бичиг);
 - 7.3.4. Бакалаврын түвшний суралцагч бол бүрэн дунд, магистрын түвшний суралцагч бол бакалаврын зэргийн, докторын түвшний суралцагч бол магистрын боловсрол эзэмшсэнийг баглах баримт бичиг;

- 7.3.5. Бакалаврын түвшний суралцагч тухайн сургуульд элсэхдээ өгсөн ЭШ-ын батламж бичиг;
- 7.3.6. Цээж зураг (зургийн шаардлагыг бүртгэлийн нэгдсэн системээс үзэх).
- 7.4. Энэхүү журмын 7.3-т заасан гадаад хэлээрх бичиг баримтын монгол хэлний орчуулгыг нотариатаар батлуулсан байна.
- 7.5. Бүртгүүлэгч нь хэд хэдэн хөтөлбөрт шилжин суралцах хүсэлт гаргаж болно.
- 7.6. Бүртгүүлэгч нь бүртгэлийн системд бичиг баримтыг дутуу болон буруу оруулсан тохиолдолд шилжилтийн шалгалтад оруулахгүй байх үндэслэл болно.

НАЙМ. ШИЛЖИЛТИЙН ШАЛГАЛТ

- 8.1. Бүртгүүлэгч нь товлосон хугацаанд хөтөлбөрийн шаардлагын дагуу шалгалт өгнө.
- 8.2. Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгж нь шалгалт авах хугацаа, байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хаагдахаас долоо хоногийн өмнө бүртгэлийн нэгдсэн систем <http://burtgel.num.edu.mn>-д байршуулна.
- 8.3. Бүртгүүлэгч шалгалтын дүнг бүртгэлийн нэгдсэн системд нэвтэрч шалгана.
- 8.4. Шалгалтад авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг оноогоор нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- 8.5. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө суралцсан сургуулийн голч дүнг харгалзана.

ЕС. ШИЛЖИН СУРАЛЦАХ ЭРХ ОЛГОХ

- 9.1. Бүртгүүлэгч хэд хэдэн хөтөлбөрт бүртгүүлж, шалгуулж болох ба зөвхөн нэг хөтөлбөрт шилжин суралцах эрх авна.
- 9.2. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч нь гадаад болон бусад их дээд сургуулиас шилжин ирж байгаа бол Боловсролын яамны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд өмнө сурч байсан мэдээллээ оруулсан байх ба шалгалт авсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан бүртгэлийн системд оруулсан баримт бичгийг эх хувиар нь битүүмжилсэн хавтсанд хийж бүрэлдэхүүн/салбар сургуулийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд бүртгүүлэн, сургалтын мэдээллийн систем ашиглах эрх авна.
- 9.3. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч нь энэхүү журмын 9.2-т заасны дагуу бүртгүүлээгүй бол шилжин суралцахаас татгалзсан гэж үзэж, энэхүү журмын 8.4-т заасан шаардлагыг биелүүлсэн дараагийн хүнд эрхийг шилжүүлнэ.
- 9.4. Шилжих болзол хангаж, хяналтын тоонд багтан, шилжин суралцах эрхээ авсан суралцагчдыг МУИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулна. Тушаалд өмнө нь суралцаж байсан сургууль, хөтөлбөр, шилжин суралцах бүрэлдэхүүн/салбар сургууль, хөтөлбөр, дүйцүүлэх багц цагийн хэмжээг тусгана.

АРАВ. ШИЛЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ

- 10.1. Шилжилтийн бүртгэлийн хураамжийг МУИС-ийн Удирдах зөвлөлийн тогтоолоор тогтооно.

- 10.2.Бүртгүүлэгч нь хүсэлт гаргасан хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.
- 10.3.Бүртгэлийн хураамжийг 100 хувь МУИС-ийн төвлөрсөн санд төвлөрүүлж, шалгалт зохион байгуулах болон бусад зардалд зарцуулна.
- 10.4.Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.
- 10.5.МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг хүртсэн суралцагч МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцвал тэтгэлгийг цуцалж, олгосон тэтгэлгийг буцаан төлүүлнэ.

АРВАН НЭГ. БУСАД

- 11.1.Бүртгүүлэгч нь бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 11.2.Суралцагч МУИС-ийн хөтөлбөр хооронд 1 удаа шилжин суралцаж болно.
- 11.3.Элсэлт, хөтөлбөр сонголтоор хяналтын тоо нь гүйцээгүй хөтөлбөрт МУИС-ийн бусад хөтөлбөрөөс тусгай нөхцөлөөр шилжин суралцах асуудлыг МУИС-ийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тухайн хичээлийн жилийн хяналтын тоо гүйцээгүй хөтөлбөрийн жагсаалт, тавигдах шаардлагыг тодорхойлно.
- 11.4.Магистр, докторын хөтөлбөрт шилжих хүсэлт гаргасан бүртгүүлэгч тухайн ахисан түвшний хөтөлбөрийн элсэлтийн журмын болзлыг хангасан байна.
- 11.5.Шилжин суралцагчийн өмнө үзсэн хичээлийн багц цагийг “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-ын дагуу дүйцүүлэн тооцно.
- 11.6.Шилжилттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д шилжүүлэн суралцуулахгүй, шилжсэний дараа энэ зөрчил тогтоогдсон тохиолдолд сургуулиас хасна.